



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/355

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жишиг гудамж тохижуулах /Жаргалант сум, Наран баг/ ажлын гүйцэтгэгч “Затус” ХХК-ний ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

- Ц.Цогтбаяр - Жаргалант сумын Засаг даргын орлогч
- Гишүүд: Б.Нямдэлгэр - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч
- И.Цэрмаа - Наран багийн Засаг дарга
- Б.Чаминчулуун - Наран багийн нийгмийн ажилтан
- Нарийн бичгийн дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2. Жишиг гудамж тохижуулах /Жаргалант сум, Наран баг/ ажлыг захиалагчаас баталсан ажлын даалгаврын дагуу шалгаж хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Цогтбаяр/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ *Ц.Цогтбаяр* ЖАРГАЛСАЙХАН

